- -Бор-Өндөр сум 5 нэр төрлийн орлогыг 6.0 сая төгрөгөөр,
- -Бэрх тосгон 1 нэр төрлийн орлогыг 0.2 сая төгрөгөөр,
- -Галшар сум 4 нэр төрлийн орлогыг 3.2 сая төгрөгөөр,
- -Гурванбаян сум 3 нэр төрлийн орлогыг 1.7 сая төгрөгөөр,
- -Дадал сум 2 нэр төрлийн орлогыг 1.5 сая төгрөгөөр,
- -Дэлгэрхаан сум 4 нэр төрлийн орлогыг 1.6 сая төгрөгөөр,
- -Жаргалтхаан сум 5 нэр төрлийн орлогыг 2.2 сая төгрөгөөр,
- -Өлзийт сум 3 нэр төрлийн орлогыг 1.6 сая төгрөгөөр,
- -Өмнөдэлгэр сум 2 нэр төрлийн орлогыг 3.0 сая төгрөгөөр,
- -Мөрөн сум 2 нэр төрлийн орлогыг 0.6 сая төгрөгөөр,
- -Норовлин сум 4 нэр төрлийн орлогыг 3.5 сая төгрөгөөр,
- -Хэрлэнбаянулаан тосгон 1 нэр төрлийн орлогыг 0.2 сая төгрөгөөр,
- -Хэрлэн сум 2 нэр төрлийн орлогыг 41.3 сая төгрөгөөр,
- -Дархан сум 3 нэр төрлийн орлогыг 1.4 сая төгрөгөөр,

2017 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 9,611.2 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 1,995.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 34,307.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус хуваарийн дагуу бүрэн авсан.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 1738 иргэнд 814.2 сая төгрөгийг бүрэн олгосон.

6. Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн орлоготой холбоотой 139.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй 134.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Өндөрхаан хот тохижилтийн газар нь иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдлын үйлчилгээний хураамж болон орон нутгийн төсвийн орлогын 132.2 сая төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй, өөрийн нэмэлт дансанд авч, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23.8-т “Сум дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.12-ын “Хог хаягдлын үйлчилгээний хураамж”, Хог хаягдлын тухай хуулийн 41.8-ын “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ГБХЗХГ тоног төхөөрөмж байршуулсаны 2166,7 мянган төгрөгийн түрээсийн орлогоос суутган тооцож төсөвт төвлөрүүлэх 30% болох 0.7 сая төгрөгийг, аймгийн ЗДТГ 6512.0 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрсөний 30 хувь болох 1.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил тус тус илэрсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 сарын 20-ны 102 тоот “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй 1.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 “ Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах

болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

- Аймгийн БТСГазар 0.3 сая төгрөгөөр, Бэрх тосгоны Соёлын төв 0.4 сая төгрөгөөр, Өмнөдэлгэр сумын ЗДТГ 0.1 сая төгрөгөөр, Жаргалтхаан сумын ЗДТГ 0.4 сая төгрөгөөр, Хурх тосгоны ЗАА 0.2 сая төгрөгөөр өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

3. СХС-ийн зээлийн хүүг зөрүүтэй тооцож, Сум хөгжүүлэх сангийн холбогдох журмыг мөрдөөгүй байна.

- Зээлийн хүүг Батширээт сумын СХС 0.9 сая төгрөгөөр, Баян-Адрага сумын СХС 0.8 сая төгрөгөөр, Биндэр сумын СХС 1.3 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсоныг аудитаар санхүүгийн тайланд залруулга хийсэн байна.
- Зээлийн хүүг Батноров сумын СХС 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй, түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх орлогыг төсөвт төвлөрүүлээгүй зарцуулсан, орон нутгийн төсвийн орлогыг байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлж зарцуулсан, зээлийн хүүг зөрүүтэй тооцсон зэрэг зөрчлүүд нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

ГУРАВ. ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 58,984.6 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 56,885.1 сая төгрөгийн буюу 96.4 хувийн гүйцэтгэлтэй, 2,099.5 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Үүнээс орон нутгийн төсвийн нийт зарлага 24585.0 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 22585.7 сая төгрөгийг зарцуулж, 80.6 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Сум хөгжүүлэх сан, ЖДБДС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг хассан дүнгээр авч үзвэл: Аймгийн төсвийн нийт зарлага 56,339.0 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 55,843.8 сая төгрөгийн буюу 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн нийт зарлага 21,939.4 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 21,544.5 сая төгрөгийг зарцуулж, 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 34,399.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 34,299.3 сая төгрөгийг зарцуулж, 98.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар **53,464.6** сая төгрөгөөр баталсныг төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн төлөвлөгөөний дүнтэй тулгахад 5,520.0 сая төгрөгөөр илүү буюу **58,984.6** сая төгрөгөөр тусгажээ. Энэ нь сумдын ИТХ-аар сум хөгжүүлэх сан, ЖДБДС-ийн орлогын төлөвлөгөөг баталдаг болсонтой холбоотой 2645.6 сая төгрөг, сумын орлогыг тодотгон нэмэгдүүлсэн 2,874.4 сая төгрөг нөлөөлж байна.

Хураангуйлан харуулбал:

/сая. төгрөгөөр/

	Зарлага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Нийт дүн	58,984.61	56,885.08	2,099.52	96.4
1.1	Орон нутгийн нийт зарлага	56,339.0	55,843.8	495.2	99.1

1.2	Сумдын СХСан	1,768.4	701.8	1,066.6	39.7
1.3	Сумдын ЖДБДСан	877.2	339.5	537.7	38.7

2017 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

/дэлгэрэнгүйгээр харуулбал:/

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл ийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,984,606,000.00	56,885,083,107.98	2,099,522,892.02	96.44
УРСГАЛ ЗАРДАЛ	53,106,429,000.00	52,795,530,622.73	310,898,377.27	99.41
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,430,142,500.00	41,176,509,399.74	253,633,100.26	99.39
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,253,263,600.00	26,188,072,963.83	65,190,636.17	99.75
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,911,268,700.00	2,892,562,319.32	18,706,380.68	99.36
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,438,853,300.00	4,420,178,883.90	18,674,416.10	99.58
Хангамж, бараа материалын зардал	1,098,365,700.00	1,091,217,591.34	7,148,108.66	99.35
Нормативт зардал	2,308,966,800.00	2,305,294,010.99	3,672,789.01	99.84
Эд хогшил, урсгал засварын зардал	811,291,700.00	811,618,357.00	-326,657.00	100.04
Урсгал засвар	556,501,500.00	560,285,223.00	-3,783,723.00	100.68
Томилолт, зочны зардал	168,600,900.00	164,837,300.00	3,763,600.00	97.77
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	958,563,300.00	889,836,429.62	68,726,870.38	92.83
Бараа үйлчилгээний бусад зардал	2,480,968,500.00	2,412,891,543.74	68,076,956.26	97.26
ТАТААС	233,589,500.00	233,589,210.00	290.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,442,697,000.00	11,385,432,012.99	57,264,987.01	99.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,292,772,500.00	3,078,204,645.25	214,567,854.75	93.48
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,585,404,500.00	1,011,347,840.00	1,574,056,660.00	39.12
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,984,606,000.00	56,679,376,932.68	2,305,229,067.32	96.09
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,307,395,000.00	34,208,483,327.19	98,911,672.81	99.71
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	34,307,395,000.00	34,208,483,327.19	98,911,672.81	99.71
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,422,391,500.00	20,382,221,946.10	40,169,553.90	99.80
Орон нутгийн төсвөөс	18,427,003,000.00	18,386,833,437.05	40,169,562.95	99.78
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,995,388,500.00	1,995,388,509.05	-9.05	100.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,038,107,600.00	963,007,539.62	1,075,100,060.38	47.25
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,070,200.00	85,174,175.00	896,025.00	98.96
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	163,528,900.00	212,745,071.00	-49,216,171.00	130.10
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,788,508,500.00	665,088,293.62	1,123,420,206.38	37.19
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
БУСАД ЭХ ҮҮСВЭР	2,216,711,900.00	1,125,664,119.77	1,091,047,780.23	50.78

Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	2,216,711,900.00	1,125,664,119.77	1,091,047,780.23	50.78
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,123,051,016.95	-1,123,051,016.95	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	917,344,841.65	-917,344,841.65	0.00

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар **56,885.1** сая төгрөгийн гүйцэтгэл гарсны **52,795.5** сая төгрөг буюу 92.8 хувийг урсгал зардалд, **3,078.2** сая төгрөг буюу 5.4 хувийг хөрөнгийн зардалд, 1,011.3 сая төгрөг буюу 1.8 хувийг СХС, ЖДБДС-ийн зээл олголтонд зарцуулсан байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг нийт дүнд нь харьцуулбал цалингийн зардал 46.0 хувийг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 5.1 хувийг, тогтмол зардал 7.8 хувийг, хангамж, бараа материалын зардал 1.9 хувийг, нормативт зардал 4.0 хувийг, эд хогшил урсгал засварын зардал 1.4 хувийг, томилолтын зардал 0.3 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1.6 хувийг, татаас, бараа үйлчилгээний бусад зардал 4.3 хувийг, татаас, урсгал шилжүүлгийн зардал 20.4 хувийг, хөрөнгийн зардал 5.4 хувийг, 1.8 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс **2,099.5** сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал зардлын хэмнэлтээр төвлөрүүлсэн 80.6 сая төгрөг болон урьд оны үлдэгдлээс санхүүжих санхүүжилтийг бүрэн санхүүжүүлээгүйгээс гүйцэтгэл гаргаагүй нийт 109.7 сая төгрөг
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зардлын хэмнэлтээр төвлөрүүлсэн 98.1 сая төгрөг буюу орлогын биелэлтийн дутуу 2.2 сая төгрөг
- ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл 196.9 сая төгрөг, орлогын дутуу төвлөрөлтийн 9.1 сая төгрөг
- Халамжийн сангийн гүйцэтгэл төлөвлөгдснөөс 28.8 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан
- СХС, ЖДБДС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү 1574.1 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь тус тус нөлөөлжээ.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллагын батлагдсан төлөвлөгөө гүйцэтгэлээр авч үзвэл:

№	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	АИТХурал	320,601.90	320,600.85	1.05
2	АЗДТГазар	1,634,730.70	1,634,204.30	526.40
3	ОНӨГазар	82,602.40	81,977.48	624.92
4	Санхүүгийн хяналт аудитын алба	88,670.10	88,326.97	343.13
5	Хот тохижилт	542,268.90	542,214.39	54.51
6	БОАЖГазар	586,002.70	585,496.51	506.19
7	Халамж	7,334,906.90	7,306,154.60	28,752.30
8	Байгаль хамгаалах сан	121,439.70	56,602.23	64,837.47

9	Ангилагдаагүй зардал-Засаг дарга	165,172.70	156,593.80	8,578.90
10	Малыг эрсдлээс хамгаалах сан	248,100.00	234,194.40	13,905.60
11	ОНХСан	2,688,915.80	2,482,906.55	206,009.25
12	Замын сан	289,564.20	285,353.70	4,210.50
13	Орон нутгийн хөрөнгө оруулалт	706,400.00	701,895.44	4,504.56
14	Сумдын ЗДТГазар	6,202,786.30	6,152,154.00	50,632.30
15	Сумдын ИТХурал	927,262.40	915,792.45	11,469.95
16	Сумдын СХСан	1,768,394.20	701,784.53	1,066,609.67
17	Сумдын ЖДБДСан	877,171.90	339,483.41	537,688.49
	Орон нутгийн төсвийн дүн	24,584,990.80	22,585,735.61	1,999,255.19
18	Боловсрол, соёл	28,869,747.70	28,812,157.07	57,590.63
19	Эрүүл мэнд	4,726,595.40	4,685,070.15	41,525.25
20	ГХБХБГазар	237,747.20	236,932.35	814.85
21	ГБХЗХГазар	157,488.30	157,151.33	336.97
22	БТСГазар	408,036.60	408,036.60	-
	ТЗШилжүүлгийн байгууллагын дүн	34,399,615.20	34,299,347.50	100,267.70
	Нийт төсвийн зарлагын дүн	58,984,606.00	56,885,083.11	2,099,522.89

Төсвийн гүйцэтгэлийг сумдаар харуулбал:

/төгрөгөөр/

Сумдын нэр	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
Батноров-1814	1,937,783,900.00	1,919,040,059.00	18,743,841.00	99.0
Батширээт-1809	1,461,369,400.00	1,383,607,552.26	77,761,847.74	94.7
Баян овоо-1815	1,531,575,300.00	1,370,045,798.49	161,529,501.51	89.6
Баянадрага-1811	1,552,739,500.00	1,510,501,437.00	42,238,063.00	97.3
Баянмөнх-1803	1,165,199,100.00	1,146,980,716.61	18,218,383.39	98.4
Баянхутаг-1802	1,188,625,800.00	1,038,721,053.00	149,904,747.00	87.4
Биндэр-1810	1,947,298,400.00	1,641,562,039.00	305,736,361.00	84.3
Бор Өндөр тосгон-1827	4,504,752,500.00	4,074,148,284.75	430,604,215.25	90.4
Бэрх тосгон-1828	1,759,671,900.00	1,740,830,939.60	18,840,960.40	98.9
Галшир-1801	1,395,976,000.00	1,354,834,553.50	41,141,446.50	97.1
Гурванбаян-1818	922,216,200.00	896,824,364.56	25,391,835.44	97.2
Дадал-1812	1,642,786,200.00	1,611,472,814.00	31,313,386.00	98.1
Дархан-1804	1,276,930,400.00	1,224,319,136.00	52,611,264.00	95.9
Дэлгэрхаан-1805	1,379,378,400.00	1,344,855,913.00	34,522,487.00	97.5
Жаргалтхаан-1806	1,616,809,300.00	1,570,024,368.40	46,784,931.60	97.1
Өлзийт-1820	923,574,200.00	917,515,617.75	6,058,582.25	99.3
Өмнөдэлгэр-1808	2,367,926,800.00	2,313,410,384.00	54,516,416.00	97.7
Мөрөн-1816	1,174,299,800.00	1,133,538,469.20	40,761,330.80	96.5
Норовлин-1813	1,463,279,700.00	1,327,953,119.29	135,326,580.71	90.8

Хэнтий шууд-1800	14,774,522,500.00	14,634,634,392.74	139,888,107.26	99.1
Хэрлэн баян улаан тосгон-1819	540,933,800.00	530,608,110.20	10,325,689.80	98.1
Хэрлэн-1817	11,226,216,000.00	11,019,210,675.63	207,005,324.37	98.2
Цэнхэрмандал-1807	1,230,740,900.00	1,180,443,310.00	50,297,590.00	95.9
Дүн	58,984,606,000.00	56,885,083,107.98	2,099,522,892.02	96.44

Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ийн тодотгосон тогтоолоор 2017 онд Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд авах орлогын шилжүүлгийг **1,995.4** сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт орлого болон суурь орлогын зөрүүгээр **130.0** сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс **723.0** сая төгрөг, хандив тусламжаар 54.0 сая төгрөг, нийт **2,902.4** сая төгрөгийг баталсан байна. Үүнээс орлогын шилжүүлгийн 601.1 сая төгрөгийг Бор-Өндөр, Өндөрхаан хот тохижилтын газрууд, Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд зарцуулахаар төсвийн төслөөр хуваарилж баталсан байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн санд 677.4 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 716.9 сая төгрөгийг, урсгал зардалд 601.1 сая төгрөгийг тус тус хуваарилан олгожээ.

Мөн төсвийн тодотголоор 2017 оны жилийн эцсийн дансны үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн 46.1-д заасны дагуу урсгал зардлын эх үүсвэрт тооцож, төрийн сангийн үлдэгдлийг сумын урсгал зардал болон орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болгон зарцуулах эрхийг сумдад олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэрийг авч үзвэл орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,995.4 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар 130.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 723.0 сая төгрөг, хандив, тусламжаас 54.0 сая төгрөг, нийт 2,902.4 сая төгрөгийг 185 төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөснөөс нийт 2,696.4 сая төгрөг зарцуулж, нийт 196.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. 9.1 сая төгрөгийн зөрүү нь орлогын дутуу төвлөрөлттэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2017 онд 1995.4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг батлагдсан нь бүрэн ирсэн байна.

Аймагт 17 төсөл арга хэмжээнд 1171.6 сая төгрөгийг, суманд 160 төсөл арга хэмжээнд 1311.3 сая төгрөгийг, Хот тохижилтод 213.5 сая төгрөгийг тус тус зарцуулан оны эцэст сумд 103.8 сая төгрөг, аймаг 93.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумдаар харуулбал: /мян.төгрөгөөр /

Аймаг, сум	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
Аймаг	1,247,827.3	1,171,559.0	76,268.28	93.9
Галшар-1801	80,700.0	80,284.7	415.29	99.5
Баянхутаг-1802	89,892.7	83,204.5	6,688.18	92.6
Баянмөнх-1803	11,327.2	11,323.2	4.05	100.0
Дархан-1804	132,267.8	110,870.9	21,396.91	83.8
Дэлгэрхаан-1805	65,949.2	61,620.2	4,329.02	93.4
Жаргалтхаан-1806	210,621.8	210,180.0	441.80	99.8
Цэнхэрмандал-1807	43,277.4	43,231.0	46.40	99.9
Өмнөдэлгэр-1808	20,000.0	18,427.2	1,572.80	92.1
Батширээт-1809	120,551.3	120,551.3	-	100.0

Биндэр- 1810	74,393.4	33,623.2	40,770.19	45.2
Баян-Адрага -1811	61,300.0	60,672.7	627.30	99.0
Дадал- 1812	47,954.2	47,954.2	-	100.0
Норовлин-1813	19,929.0	19,929.0	0.05	100.0
Батноров-1814	50,300.0	50,300.0	-	100.0
Баян-Овоо 1815	52,122.2	50,573.9	1,548.34	97.0
Мөрөн-1816	34,798.8	34,666.7	132.10	99.6
Хэрлэн-1817	140,744.2	107,706.2	33,038.03	76.5
Бор-Өндөр-1827	136,545.0	121,834.6	14,710.42	89.2
Бэрх тосгон-1828	22,405.0	22,405.0	-	100.0
Гурванбаян тосгон-1818	7,306.6	7,306.6	0.05	100.0
Хэрлэнбаян-Улаан тосгон-1819	5,300.0	1,280.0	4,020.00	24.2
Өлзийт тосгон-1820	13,402.7	13,402.7	0.04	100.0
Хот тохижилт	213,459.8	213,459.8	-	100.0
Нийт дүн	2,902,375.6	2,696,366.4	206,009.2	

Цалингийн сан, орон тооны талаар:

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он				
			Анх батлагдсан сан	Тодотго сон төсөв -1	Тодотго сон төсөв -2	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5	5=4-3
I	Орон нутгийн төсөв:	29306.3	28932.1	29203.6	29164.6	29080.6	84.0
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26390.8	26061.7	26299.8	26253.3	26188.1	65.2
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2915.5	2870.4	2903.8	2911.3	2892.6	18.7
3	БАЙГУУЛЛАГЫН ТОО	242	241	241	241	241	0
	Төсвийн байгууллага	239	238	238	238	238	0
	Төсвөөс гадуур байгууллага	3	3	3	3	3	0
4	Ажиллагсад бүгд /тоо/	3293	3329	3329	3329	3344	15
	Удирдах ажилтан	286	286	286	286	286	0
	Гүйцэтгэх ажилтан	1876	1888	1888	1888	1909	21
	Үйлчлэх ажилтан	862	893	893	893	883	-10
	Гэрээт ажилтан	269	262	262	262	266	4

Орон нутгийн төсвийн байгууллагууд нь цалингийн санг 84.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 18.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан бол батлагдсан орон тоог 15 –аар хэтрүүлсэн байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд гүйцэтгэх орон тоог 21 –ээр хэтрүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд:

Хэрлэн баян-Улаан тосгоны ЗАА 1, Цэцэрлэг 1, ЕБС 1, Соёлын төв 2, Баян-Овоо сумын ЭМТ 2, Дархан ЕБС 1, Дадал сумын ЕБС 3, Цэцэрлэг 2, Соёлын төв 1, Баян-Адрага ЕБС 2, Өмнөдэлгэр ЭМТ 6, Хэрлэн баян-Улаан тосгоны ЗАА 1, Хэрлэн сумын ИТХ 1, Жаргалтхаан ЗДТГ-1, Норовлин сумын ЗДТГ 1 орон тоог хэтрүүлсэн байна.

Батлагдсан орон тооны хэтрэлтийг сумдаар тооцвол: Өмнөдэлгэр сум 6, Дадал сум 6, Хэрлэнбаян-Улаан тосгон 5, Баян-Овоо сум 2, Баян-Адрага сум 2, Дархан сум 1, Жаргалтхаан

сум 1, Норовлин сум 1, Хэрлэн сум 1 орон тоо хэтэрсэн байна.

Дээрхи зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтад нийцээгүй, УИХ-ын 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар батлагдсан орон тоог баримтлаж ажиллах тухай албан шаардлагыг Норовлин сумын ЗДТГ, Дархан сумын ЕБС-ийн төсвийн захирагч нарт хүргүүлж, 7 сумын ТЕЗ-д зөвлөмж хүргүүлсэн.

❖ **Санхүүгийн тайлангийн аудитаар нийт төсвийн зарцуулалттай холбоотой 133.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.**

Төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчлүүдийг танилцуулвал:

1. Шүүхийн шийдвэр болон бусад тогтоол шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан албан тушаалтнуудад 32.0 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:
 - Шүүхийн шийдвэрээр Бор-Өндөр ЗДТГ 18.1 сая төгрөг, Бор-Өндөр Цогцолбор сургууль 3.1 сая төгрөг, Хурх ЭМТ 2.4 сая төгрөг, Хурх Соёлын төв 1.0 сая төгрөг, БОАЖГазар 3.9 сая төгрөг, Бэрх ЗАА төрийн албан зөвлөлийн тогтоолоор 3.4 сая төгрөгийг тус тус олгосон.
2. Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан 28.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:
 - Нийтлэг үйлчилгээний газар ажилласан цагийн бүртгэл байхгүй, бүрдэл дутуу баримтаар 1 ажилтанд нийт 5.4 сая төгрөгийн цалин олгосон байна.
 - Нийтлэг үйлчилгээний газар бичиг хэргийн ажил хавсарсан нэмэгдэлд 1.9 сая төгрөгийг олгосон.
 - Бор-Өндөр сумын ИТХ өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан 2.4 сая төгрөгийн урамшуулал, төрийн захиргааны албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулалд 0.6 сая төгрөгийг олгосон.
 - Өлзийт тосгоны ЕБС өмнө ажиллаж байсан нягтлан бодогчийг 2017 оны 9 дүгээр сард бүтцийн өөрчлөлтөөр гэж халаад 10 дугаар 01 нээс шинээр нягтлан бодогч томилсон. Бүтцийн өөрчлөлтөөр халагдсан тул ажлаас халагдсан тэтгэмж 1.6 сая төгрөгийг цалингийн зардлаас гаргаж өгсөн.
 - Хурх тосгоны ЭМТ үр дүнгийн урамшуулалтай давхцуулж 2.0 сая төгрөгийн шагналт цалинг хавтгайруулан олгосон.
 - Мөрөн сумын ЕБС ажиллагсад ур чадварын нэмэгдлийг заавар журамд нийцүүлэн олгоогүй, сургуулийн 70 жилийн ойг тохиогдуулан хавтгайруулан 7 хүнд 0.9 сая төгрөгийг, Жаргалтхаан сумын Цэцэрлэг ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтгүйгээр 0.8 сая төгрөгийг тус тус олгосон.
 - Цэнхэрмандал сумын ЗДТГ урсгал засварын зардлаас 8.4 сая төгрөгийг ЗДТГазрын эзэмшил бүхий НИССАН ПАТРОЛ автомашинд засвар хийхээр “Сүжийн тал хоршоо” ХХК-тай гэрээ хийж шилжүүлсэн боловч, сумын комисс засварыг ажлыг хангалтгүй хүлээн авсан, автомашин ажлын шаардлага хангахгүй байгаа нь төсвийг хэт үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан байна.
 - Хэрлэн сумын 4-р сургууль 6 сургалтын төвтэй гэрээ хийж, багш, сурагчид, ажиллагсадын мэдлэг чадвар, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх зорилгоор

- 4.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч, сургалтанд хэдэн багш, сурагчид, ажиллагсад оролцсон мэдээ тайлан, гүйцэтгэл, санхүүгийн баримтыг бүрдүүлээгүй.
- Мөрөн сумын ИТХ тэргүүлэгчдэд урамшуулал олгохдоо хуралдааны тогтоолоор тогтоосон хэмжээнээс нийт 0.1 сая төгрөгөөр илүү олгосон, ОНӨА сахилгын шийтгэлтэй хүнд 0.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.
3. Зардлын зүйл ангийг баримтлахгүй, зориулалт бусаар зарцуулсан 45.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 –ын “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Сангийн Сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” журмыг зөрчин, санхүүгийн тайлангийн үнэн зөв ба эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:
- Цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж урамшуулал, нийгмийн даатгалын зардалд аймгийн ГХБХБГ 2.4 сая төгрөг, Баян-Адрага сумын ЗДТГ 0.9 сая төгрөг, Цэцэрлэг 0.5 сая төгрөг, Соёлын төв 0.2 сая төгрөг, Батширээт сумын Цэцэрлэг 0.7 сая төгрөг, Галшар сумын ЗДТГ 0.7 сая төгрөг, Биндэр сумын Цэцэрлэг 0.1 сая төгрөг, ЗДТГ 2.0 сая төгрөг, ИТХ 0.9 сая төгрөг, Баянхутаг сумын ЕБС 0.4 сая төгрөг, Цэцэрлэг 0.4 сая төгрөг, ИТХ 0.2 сая төгрөг, Өлзийт Захирагчийн алба 0.9 сая төгрөг, Баян-Овоо сумын ЭМТ 0.3 сая төгрөг, Батноров сумын ЭМТ 1.2 сая төгрөг, нийт 11.8 сая төгрөгийг төлсөн байна.
 - Бусад зардлуудаас Жаргалтхаан сумын ИТХ 4.1 сая төгрөгийн, Өмнэдэлгэр сумын ЭМТ 4.6 сая төгрөгийн, Хан хэнтий чуулга 4.8 сая төгрөгийн, СХАА 0.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан.
 - Норовлин сумын ОНХС 3.4 сая төгрөгийг, Дархан сумын ОНХС 1.9 сая төгрөгийг төсөл арга хэмжээ тодорхойгүй шатахууны үнэд төлж, урсгал зардалд зарцуулсан.
 - Зардлын зүйл ангийг зөрчин Мөрөн сумын ЕБС 1.0 сая төгрөгийн, ИТХ 1.2 сая төгрөгийн, Баянмөнх сумын ЗДТГ 2.9 сая төгрөгийн, Галшар сумын Соёлын төв 0.8 сая төгрөгийн, Цэцэрлэг 0.9 сая төгрөгийн, ЭМТ 0.4 сая төгрөгийн, ЕБС 0.1 сая төгрөг, Өндөрхаан хот тохижилт 1.6 сая төгрөгийн, Орон нутгийн музей 0.6 сая төгрөг, Хан Хэнтий цогцолбор сургууль 4.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
4. Зардлын зүйл ангийг зөрүүлэн бүртгэсэн 19.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Сангийн Сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” журмыг зөрчин, санхүүгийн тайлангийн үнэн зөв ба эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:
- Аймгийн ИТХ 6.8 сая төгрөг, аймгийн ЗДТГ 3.1 сая төгрөг, Өлзийт тосгоны Цэцэрлэг 0.2 сая төгрөг, Баянмөнх сумын ЗДТГ 2.8 сая төгрөг, ЕБС 4.5 сая төгрөг, Соёлын төв 1.4 сая төгрөг Норовлин сумын цэцэрлэг 0.1 сая төгрөг, Цэнхэрмандал Цэцэрлэг 0.3 сая төгрөгийн зардлуудыг зүйл анги зөрүүлэн бүртгэсэн байна.
5. Хүүхдийн хоолны зардлын норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан 2.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын холбогдох заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:
- Жаргалтхаан сумын Цэцэрлэг 147.8 мянган төгрөг, Хэрлэн 5-р цэцэрлэг 1,177.4 мянган төгрөг, Хэрлэн 7-р цэцэрлэг 680.0 мянган төгрөг, Өлзийт цэцэрлэг 348.9 сая төгрөг, Хан Хэнтий Цогцолбор сургууль дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 324.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

6. Илүү цагийн хөлс болон ур чадварын нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон 5.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- Мөрөн сумын ЭМТ 0.4 сая төгрөг, Жаргалтхаан сумын ЭМТ 0.6 сая төгрөг, Өлзийт тосгоны 0.9 сая төгрөг, Дэлгэрхаан сумын ЭМТ 2.4 сая төгрөг, Цэнхэрмандал сумын ЭМТ 0.3 сая төгрөг, Галшар сумын ЭМТ 0.6 сая төгрөгийн, нийт 5.2 сая төгрөгийн эмч, сувилагч нарын илүү цагийг тооцохдоо, сарын цагийн фонд, нэг цагийн дундаж хөлсийг буруу тооцож олгосон.
 - Мөрөн сумын ЕБС ур чадварын нэмэгдлийг 0.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон.

Дээрхи зөрчлүүд нь төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь санхүүгийн үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, заавар журмыг бүрэн мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

ДӨРӨВ: ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт орлогоос нийт зардлыг хасч төсвийн үр дүнг гаргахад гүйцэтгэлээр 2295.3 сая төгрөг байна. Үүнд сум хөгжүүлэх сан, ЖДБДС-ийн зээлийн орлогын төлөвлөгөө /эргэн төлөгдөх цэвэр зээл/ 2,585.4 сая төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 1,011.3 сая төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Төсвийн үр дүнгийн үзүүлэлт

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 он			
	Анх батлагдсан	Тодотгосон төсөв - 2	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	53,065.1	58,984.6	59,180.4	195.8
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	7,905.7	9,119.3	11,641.0	2,521.7
1.Татварын орлого	7,414.2	8,084.9	10,229.2	2,144.3
2.Татварын бус орлого	491.5	1,034.4	1,411.8	377.4
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	100.0	100.0	97.9	(2.1)
В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	45,059.4	49,765.3	47,441.5	(2,323.8)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,065.1	58,984.6	56,885.1	(2,099.5)
А. УРСГАЛ ЗАРЛАГА	49,339.1	53,106.4	52,795.6	(310.8)
1. Бараа, үйлчилгээний зардал	39,385.2	41,430.2	41,176.5	(253.7)
1.1 Цалин, хөлс	26,061.7	26,253.3	26,188.1	(65.2)
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл	2,870.4	2,911.3	2,892.6	(18.7)
1.3 Бараа, үйлчилгээний бусад зардал	10,453.1	12,265.6	12,095.9	(169.7)
2. Зээлийн үйлчилгээний төлбөр				-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	9,953.9	11,676.2	11,619.0	(57.2)
3.1 Татаас	132.3	233.6	233.6	(0.0)
3.2 Урсгал шилжүүлэг	9,821.6	11,442.6	11,385.4	(57.2)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,764.6	3,292.8	3,078.2	(214.6)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	961.4	2,585.4	1,011.3	-
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	961.4	2,585.4	1,011.3	
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл				
УРСГАЛ ТЭНЦЭЛ	(41,433.4)	(43,987.1)	(41,154.5)	2,832.6
НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	2,295.3	2,295.3
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР				
2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	120.9	1,788.5	665.1	(1,123.4)
3. Зээлийн эргэн төлөлт	891.6	2,216.7		(2,216.7)

Тусгай зориулалтын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийг хасаж тооцвол:

Үзүүлэлт	2017 он		
	Тодотгосон төсөв - 2	Гүйцэтгэл	Зөрүү
А	2	3	4=3-2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	11,214.7	13,734.3	2,519.6
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	9,119.3	11,641.0	2,521.7
1.Татварын орлого	8,084.9	10,229.2	2,144.3
2.Татварын бус орлого	1,034.4	1,411.8	377.4
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	100.0	97.9	(2.1)
В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,995.4	1,995.4	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,585.0	22,585.8	(1,999.2)
А. УРСГАЛ ЗАРЛАГА	18,706.8	18,496.2	(210.6)
1. Бараа, үйлчилгээний зардал	10,633.1	10,458.2	(174.9)
1.1 Цалин, хөлс	5,876.2	5,853.6	(22.6)
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл	653.8	646.4	(7.4)
1.3 Бараа, үйлчилгээний бусад зардал	4,103.1	3,958.2	(144.9)
2. Зээлийн үйлчилгээний төлбөр			-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	8,073.7	8,038.0	(35.7)
3.1 Татаас	60.7	60.7	-
3.2 Урсгал шилжүүлэг	8,013.0	7,977.3	(35.7)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,292.8	3,078.2	(214.6)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	2,585.4	1,011.3	(1,574.1)
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	2,585.4	1,011.3	(1,574.1)
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл			
УРСГАЛ ТЭНЦЭЛ	(9,587.5)	(6,855.2)	2,732.3
НИЙТ ТЭНЦЭЛ	(13,370.3)	(8,851.4)	4,518.9
Нийт тэнцэл эргэн төлөгдөх цэвэр зээлийг хассан дүнгээр	(10,784.9)	(7,840.1)	2,944.8

Орон нутгийн төсвийн орлогоос нийт зардлыг хасч төсвийн үр дүнг гаргахад төлөвлөгөөгөөр – 13,370.3 сая төгрөг , гүйцэтгэлээр – 8,851.4 сая төгрөг байна. Үүнд сум хөгжүүлэх сангийн зээлийн орлогын төлөвлөгөө /эргэн төлөгдөх цэвэр зээл/ 2,585.4 сая төгрөгөөр төлөвлөгдөж гүйцэтгэлээр 1,011.3 сая төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлээс СХС, ЖДБДС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийг хасч тооцвол нийт зарлагын төлөвлөгөө 21,999.6 сая төгрөг, гүйцэтгэл 21,574.5 сая төгрөг болж нийт тэнцэл төлөвлөгөөгөөр -10,784.9 сая төгрөг, гүйцэтгэлээр -7,840.1 сая төгрөг байна.

ТАВ. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Тайлант онд орон нутгийн салбарын байгууллагууд 2095.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ. Үүний 74.5 хувийг орон нутгийн төсвийн байгууллагууд, 16.7 хувийг боловсролын байгууллага, 2.4 хувийг Хүүхэд гэр бүл залуучуудын газар, 0.8 хувийг Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 5.6 хувийг ГХБХБГазар зарцуулжээ.

/сая.төг/

№	Салбарын болон байгууллагын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он	
			Санхүүжилт	Зарцуулалт

1	Орон нутгийн төсвийн байгууллагууд	1,793.2	1,561.3	1,561.3
2	Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	306.1	348.4	348.4
3	Эрүүл мэндийн сайд	25.2	16.1	16.1
4	Барилга хот байгуулалтын сайд	90.2	119.5	119.5
5	Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	30.6	50.6	50.6
	Дүн	2,245.3	2,095.9	2,095.9

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар төсвийн орлого болон зарцуулалттай холбоотой нийт 272.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн аудитаар 0.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 5.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг дахин давтахгүй байх талаар 87 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын дүн

ТЕЗ-ийн 2017 оны жилийн төсвийн гүйцэтгэлийн байдалд хийсэн аудитаас үзэхэд жилийн төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

1. ТЕЗ-ийн 2017 оны орлого, зарлагын төсөвт Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу тодотгол хийгдсэн байна.
2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 11,874.7 сая төгрөг буюу 126.8 хувиар батлагдсан төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч 4 төрлийн орлого 70.9 сая төгрөг буюу 2.1- 19.2 хувиар тасарсан байна.
3. Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 56,885.1 сая төгрөгийн буюу 96.4 хувийн гүйцэтгэлтэй байна.
4. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 139.9 сая төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 133.0 сая төгрөгийн, нийт 272.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
5. Орон нутгийн төсвийн тэнцэл нийт 2,295.3 сая төгрөг байгаа бөгөөд тусгай зориулалтын шилжүүлгийн дүнг хасч тооцвол 8,715.7 сая төгрөг байна.
6. Нэмэлт төсвөөр 2095.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зөвлөмж

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваад:

1. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, байгууллагын удирдлагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулдаг байдлыг цаашид давтахгүй байхад анхаарч ажиллах.

2. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах талаар холбогдох байгууллагад чиглэл өгч ажиллах.
3. Төсөвт зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайланд үнэн зөв илэрхийлэхэд тавих төрийн сангийн дотоод хяналтыг сайжруулах

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2018.04.24